

ДОРНОД АЙМАГ
БҮСИЙН ОНОШИЛГОО ЭМЧИЛГЭЭНИЙ
ТӨВИЙН ЗАХИРЛЫН ТУШААЛ

2025 оны 06 сарын 09 өдөр

Дугаар А/39

Чойбалсан

Дүрэм батлах тухай

Монгол улсын Засгийн газрын 2001 оны 194 дүгээр тогтоол, Эрүүл мэндийн тухай хуулийн 16.16 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Бүсийн оношилгоо эмчилгээний төвийн үйл ажиллагаандаа баримтлан ажиллах дүрмийг хавсралтаар баталсугай.

2. Дүрмийг мөрдөн, хэрэгжүүлж ажиллахыг Бүсийн оношилгоо эмчилгээний төвийн нийт ажилтнуудад үүрэг болгосугай.

3. Дүрмийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Эмнэлзүй эрхэлсэн дэд захирал /Ж.Энхчимэг/, Үйл ажиллагаа эрхэлсэн дэд захирал /Б.Өнөболд/, Сургалт эрдэм шинжилгээ, гадаад харилцааны албаны дарга /Х.Ууганцэцэг/ нарт тус тус даалгасугай.



Бүсийн оношилгоо эмчилгээний төвийн захирлын
2025 оны ...06... дугаар/дүгээр сарын ...09... ны/ний
өдрийн ...139... дугаар/дүгээр тушаалын хавсралт

ДОРНОД АЙМАГ ДАХЬ БҮСИЙН ОНОШИЛГОО ЭМЧИЛГЭЭНИЙ ТӨВИЙН ДҮРЭМ

НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1. Бүсийн оношилгоо эмчилгээний төв (цаашид Төв гэх) нь хүн амд нотолгоонд суурилсан төрөлжсөн мэргэшлийн тусламж үйлчилгээ үзүүлэхийн зэрэгцээ инновац, дэвшилтэт технологид тулгуурласан оношилгоо, эмчилгээний лавлагаа тусламж, сургалт, эрдэм шинжилгээний үйл ажиллагаа эрхэлж, бусад эрүүл мэндийн байгууллагад мэргэжил арга зүйн дэмжлэг үзүүлдэг байгууллага байна.
2. Төвийн зорилго нь бүс нутгийн хүн амд үзүүлэх эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулж, дэвшилтэт, аюулгүй, тогтвортой эрүүл мэндийн тогтолцоог бүрдүүлэхэд оршино.
3. Төв нь үйл ажиллагаандаа Монгол Улсын хууль тогтоомж, эрүүл мэндийн хөгжлийн бодлого, Дэлхийн Эрүүл мэндийн байгууллага, олон улсын байгууллагын зөвлөмж, энэхүү дүрэм болон түүнтэй нийцүүлэн батлагдсан дотоод журам, дүрмийг мөрдлөг болгоно.
4. Төвийн үйл ажиллагаа нь улсын болон орон нутгийн төвлөрсөн төсөв, эрүүл мэндийн даатгалын сан, гадаад дотоодын буцалтгүй тусламж, хандив, төсөл, хөтөлбөр, өөрийн үйл ажиллагааны орлого зэрэг санхүүгийн эх үүсвэрээр хэрэгжинэ.
5. Төвийг өөрчлөх, татан буулгах асуудлыг Монгол Улсын Засгийн газар шийдвэрлэнэ.
6. Төв нь албан бичгийн хэвлэмэл хуудас, албан тэмдэг, цахим гарын үсэг бүхий мэдээллийн платформыг холбогдох журам, стандартад нийцүүлэн ашиглана.
7. Төв нь эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага болон Засаг даргын Тамгын газартай гэрээ байгуулан ажиллаж, бүс нутгийн болон орон нутгийн эмнэлгүүдтэй хамтран ажиллах, түншлэх, уялдаа холбоотой үйл ажиллагаа явуулна.

ХОЁР. УДИРДЛАГА БА ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

8. Төв нь стратегийн бодлого, зорилт, төлөвлөгөөг хэлэлцэн батлах, гүйцэтгэлийн үр дүнд хяналт тавих, захирлын үйл ажиллагаанд үнэлэлт, дүгнэлт өгөх үүрэг бүхий Төлөөлөн удирдах зөвлөлтэй байна.
9. Төлөөлөн удирдах зөвлөлийн бүрэлдэхүүн, түүнд тавигдах шаардлага нь Эмнэлгийн тусламж, үйлчилгээний тухай хууль болон холбогдох журамд нийцнэ.
10. Төвийн гүйцэтгэх удирдлага нь Төлөөлөн удирдах зөвлөлөөс сонгон шалгаруулж, томилсон эмнэлгийн захирал байна.
11. Төвийн дэд захирлуудыг Төлөөлөн удирдах зөвлөлтэй зөвшилцөн, захирал томилж, чөлөөлнө.
12. Захирал нь эрүүл мэндийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн болон Төлөөлөн удирдах зөвлөлтэй үр дүнгийн гэрээ байгуулан ажиллаж, хэрэгжилтийг тайлагнана.
13. Төв нь эмнэл зүй, инновацын хөгжүүлэх, сургалт, эрдэм шинжилгээ, дотоод аудит, эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн асуудлаар ажиллах мэргэжлийн хороо, багтай байна.
14. Төвийн зохион байгуулалтын бүтэц, орон тоог төрийн захиргааны төв байгууллагатай зөвшилцөн захирал батална.

ГУРАВ. ТӨВИЙН ҮНДСЭН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЧИГЛЭЛ

15. Оношилгоо, эмчилгээний үйл ажиллагаанд дэвшилтэт техник, технологи болон алсын зайн тусламж, үйлчилгээ (telemedicine)-г нэвтрүүлэх, хөгжүүлэх;
16. Эрүүл мэндийн мэдээллийн удирдлагын тогтолцоог бүрдүүлж, өгөгдөлд суурилсан шийдвэр гаргалтын үйл явцыг хэрэгжүүлэх ;
17. Эм, эмнэлгийн хэрэгслийн аюулгүй байдал, тусламж, үйлчилгээний чанарт хяналт тавих, эмнэлгийн тусламжийн алдааг бууруулах, урьдчилан сэргийлэх тогтолцоог хэрэгжүүлэх;
18. Цахим бүртгэл, цахим оношилгоо, эмчилгээний төлөвлөгөө, хяналтын системд суурилан үйлчилгээг удирдан зохион байгуулах.

- 19.Бүсийн хэмжээнд нотолгоонд суурилсан эмчилгээний стандартуудыг хэрэгжүүлж, сургалт, эрдэм шинжилгээ, эмнэл зүйн аудит, инновацыг дэмжин хөгжүүлэх;
- 20.Төвийн болон бүс нутгийн эрүүл мэндийн байгууллагын эмч, эмнэлгийн мэргэжилтнүүдийг чадавхжуулах, мэргэжлийн заавар зөвлөмжөөр хангах;
- 21.Үйлчлэх бүсийн аймаг, сумдаас ирсэн төрөлжсөн мэргэшлийн яаралтай тусламжийн дуудлагыг шуурхай хүлээн авч зохицуулж, холбогдох арга хэмжээг цаг алдалгүй хэрэгжүүлэх.
- 22.Эмнэлгийн тусламж, үйлчилгээний заавар, журам, даалгавар, хяналтын хуудас боловсруулан баталж, мөрдүүлэх;
- 23.Бүсийн хэмжээнд төрөлжсөн мэргэшлийн явуулын багийг эмнэлгүүдээс бүрдүүлэн тусламж, үйлчилгээ үзүүлэх;
- 24.Орон нутгийн эрүүл мэндийн байгууллагуудтай гэрээ байгуулан хамтран ажиллаж, үйл ажиллагааг уялдуулан зохион байгуулах ;
- 25.Оношилгоо, эмчилгээний чанар, алдааны талаарх мэдээлэл цуглуулж, дүгнэлт хийж, шаардлагатай тохиолдолд лавлагаа шаардах;
- 26.Эрүүл мэндийн бодлого, зохицуулалттай холбогдох асуудлаар төрийн захиргааны төв байгууллага болон орон нутгийн засаг захиргааны байгууллагад санал хүргүүлж, шийдвэрлүүлэх ажлыг зохион байгуулах;
- 27.Гадаад, дотоодын байгууллагатай хамтран ажиллах, туршлага солилцох, төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэх түншлэл байгуулах;

ДӨРӨВ. ХАМТЫН АЖИЛЛАГАА, САНХҮҮЖИЛТ

- 28.Төв нь жил бүр улсын болон орон нутгийн төсөв, эрүүл мэндийн даатгалын сангаас авах санхүүжилтийн санал, төлөвлөгөөг боловсруулан холбогдох байгууллагад хүргүүлэн батлуулна.
- 29.Эмч, эмнэлгийн мэргэжилтнийг бэлтгэх, мэргэшүүлэх, давтан сургах төлөвлөгөөг холбогдох байгууллагаар батлуулан хэрэгжүүлнэ.
- 30.Судалгаа, шинэ технологийн туршилт, нотолгоонд суурилсан клиник төслийг боловсруулан, Анагаах ухааны үндэсний хүрээлэн болон бусад холбогдох байгууллагатай хамтран хэрэгжүүлнэ.

31.Эмч, эмнэлгийн мэргэжилтнийг чадавхжуулах, тусламж, үйлчилгээний чанарыг сайжруулах, шаардлагатай тоног төхөөрөмжөөр хангагдахад орон нутгийн засаг захиргааны санхүүгийн дэмжлэг авч ажиллана.

32.Төв нь бүсийн аймгуудын Эрүүл мэндийн газартай тусламж, үйлчилгээ болон зардлын зохицуулалтын гэрээ байгуулан, төрөлжсөн мэргэшлийн тусламж, үйлчилгээг үзүүлнэ.

ТАВ. ЧАНАР, ХЯНАЛТ, ҮНЭЛГЭЭ

33.Төв нь оношилгоо, эмчилгээний чанарт сар бүр хяналт тавьж, дотоод аудит, гүйцэтгэлийн үнэлгээг тогтмол зохион байгуулан, үр дүнг Төлөөлөн удирдах зөвлөлд тайлагнана.

34.Төв нь эрсдэлийн удирдлагын тогтолцоог хэрэгжүүлж, эмчилгээний алдаа, тохиолдлыг бүртгэн, дүн шинжилгээ хийж, урьдчилан сэргийлэх арга хэмжээ авч ажиллана.

35.Өвчтөний сэтгэл ханамжийн судалгаа, гомдлын менежментийн цахим системийг нэвтрүүлж, хэрэглэгчийн гомдол, санал, хүсэлтийг шуурхай шийдвэрлэх үйл ажиллагаа хэрэгжүүлнэ.

ЗУРГАА. БУСАД ЗААЛТ

36. Энэхүү дүрмийг шинэчлэх, нэмэлт өөрчлөлт оруулах асуудлыг Төлөөлөн удирдах зөвлөл хэлэлцэн шийдвэрлэнэ.

37.Дүрэмд заасан үүрэг, үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд холбогдох хууль, журам, стандарт, аргачлалыг удирдлага болгон ажиллана.